



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/МЧ

Шивээговь сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
 хугацаа сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бласт ХХК /2688336/ нь Шивээговь сумын 2 дугаар баг, Шивээ Овоо уурхайн хойно байрлах “Үйлдвэрлэлийн барилга, байгууламж бусад газар”-ын зориулалттай 3.5 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй Бласт ХХК-ийн гүйцэтгэх захирал (А.Тэмүүлэн)-д газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг үүрэг болгосугай.

3.Бласт ХХК-ийн захирал А.Тэмүүлэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 27 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА